

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Булган сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны
санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/88/НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Ховд хот
2022 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас:70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ч. Мөнхцооз

Утас: 99028555

цахим хаяг: munhuu8555@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	5
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Аудитын тайлан	9
3.1 Ерөнхий зүйл.....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Материаллаг байдал.....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	12
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	13
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
4. Аудитын илрүүлэлт.....	15
4.1 Залруулсан алдаа.....	15
4.2 Төлбөрийн акт.....	15
4.3 Албан шаардлага.....	15
4.4 Зөвлөмж	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХАОАТ	Хүн амын орлогын албан татвар

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	83,802,559	101,731,938
33	АВЛАГА	59,000	13,900,000
335	Бусад авлага	59,000	13,900,000
3351	Байгууллагаас авах авлага	00	13,000,000
3352	Хувь хүмүүсээс авах авлага	59,000	900,000
35	БАРАА МАТЕРИАЛ	83,743,559	87,831,938
351	Түүхий эд материал	38,400	38,400
35130	Эм боох материал	38,400	38,400
354	Хангамжийн материал	83,705,159	87,793,538
35410	Бичиг хэргийн материал	400,000	400,000
35420	Аж ахуйн материал	48,511,838	47,524,338
35440	Түлш, шатах тослох материал	18,285,225	35,020,000
35460	Хүнсний материал	16,201,136	4,779,200
35470	Бусад хангамжийн материал	70,000	70,000
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,538,696,037	3,022,199,011
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,538,696,037	3,022,199,011
392	Биет хөрөнгө	1,491,696,037	2,975,199,011
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,472,873,699	2,972,873,699
39202	Хуримтлагдсан элэгдэл	-172,363,835	-221,866,584
39203	Авто-тээврийн хэрэгсэл	23,500,000	23,500,000
39204	Хуримтлагдсан элэгдэл	-23,500,000	-23,500,000
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	393,168,425	409,761,687
39206	Хуримтлагдсан элэгдэл	-368,970,074	-372,668,726
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	221,292,373	238,391,618
39208	Хуримтлагдсан элэгдэл	-137,765,483	-135,845,525
39214	Бусад үндсэн хөрөнгө	22,750,000	22,750,000
39215	Хуримтлагдсан элэгдэл	-13,806,250	-16,081,250
39217	Ном	74,517,181	77,884,092
393	Биет бус хөрөнгө	47,000,000	47,000,000
39301	Програм хангамж	275,000	275,000
39302	Хуримтлагдсан элэгдэл	-275,000	-275,000
39303	Бусад биет бус хөрөнгө	47,000,000	47,000,000
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III-I+II	1,622,498,597	3,123,930,949
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00	10,421,501
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00	10,421,501
413	Өглөг	00	10,421,501
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00	16,269,004
4136	Бусад өглөг	00	-5,847,503
41361	Байгууллагад төлөх өглөг	00	-5,847,503
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,622,498,597	3,113,509,449
51	Засгийн газрын хувь оролцоо	1,622,498,597	3,113,509,449
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	699,055,330	699,055,330
51101	Өмч: - төрийн	699,055,330	699,055,330
512	Хуримтлагдсан үр дүн	-342,502,464	1,149,220,208
51210	Өмнөх үеийн үр дүн	-342,502,464	-341,790,644
51220	Тайлант үеийн үр дүн	00	1,491,010,852
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,265,945,730	1,265,233,910
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI-I+V	1,622,498,597	3,123,930,949

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,774,344,674	3,296,733,256
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	34,935,782	1,578,610,486
120	Нийтлэг татварын бус орлого	34,935,782	1,578,610,486
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	34,935,782	1,578,610,486
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000	600,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,029,000	15,089,430
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	31,506,782	1,562,921,056
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	111,157,692	148,783,670
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,628,251,200	1,569,339,100
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,450,000	62,363,353
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00	10,600,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00	49,694,420
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000	2,068,933
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,156,300	86,355,200
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,156,300	86,355,200
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	23,551,392	65,117
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	23,551,392	65,117
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,830,499,996	1,805,722,405
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,830,499,996	1,805,722,405
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,669,706,556	1,684,778,136
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,311,882,487	1,281,392,308
210101	Үндсэн цалин	924,295,966	1,163,607,338
210102	Нэмэгдэл	264,707,287	117,784,970
210104	Урамшуулал	122,879,234	00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	164,245,489	166,533,997
210201	Тэтгэврийн даатгал	112,819,819	140,639,138
210202	Тэтгэмжийн даатгал	13,226,370	25,894,858
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,665,300	00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,666,300	00
210205	Эрүүл мэндийн даатгал	24,867,700	00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,657,582	66,346,147
210301	Гэрэл, цахилгаан	13,191,557	9,812,922
210302	Түлш, халаалт	45,942,525	55,858,225
210303	Цэвэр, бохир ус	523,500	675,000
2104	Хангамж, бараа материалын зардал	19,732,404	9,339,700
210401	Бичиг хэрэг	1,185,600	1,055,000
210402	Тээвэр, шатахуун	8,012,260	4,864,000
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,897,954	951,900
210404	Ном, хэвлэл	860,000	453,400
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	669,500	453,700
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,107,090	1,561,700
2105	Нормативт зардал	46,886,494	57,200,376
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,200,520	3,684,600
210502	Хоол, хүнс	36,629,274	50,455,226
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,056,700	3,060,550
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,360,910	2,528,810
210604	Урсгал засвар	2,360,910	2,528,810
2107	Томиллот, зочны зардал	540,000	430,000

Булган сумын ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210702	Дотоод албан томилолт	540,000	430,000
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392,000	5,730,578
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00	4,722,578
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000	1,008,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	64,009,190	95,276,220
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	602,800	602,777
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,483,784	7,925,000
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	58,922,606	86,748,443
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160,793,440	120,944,269
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,736,792	87,453,637
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	23,551,392	65,117
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,185,400	37,694,100
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00	49,694,420
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00	32,087,698
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00	32,087,698
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00	1,402,934
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00	1,402,934
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-56,155,322	1,491,010,852
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-56,155,322	1,491,010,852

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нэээрх үлдэгдэл	662,055,330	885,291,362	1,324,564,764	00	2,871,911,456
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	662,055,330	885,291,362	1,324,564,764	00	2,871,911,456
C07	Тайлант үеийн үр дүн	00	00	21,241,192	00	21,241,192
C08	2020 оны 12-р сарын 31-нэээрх үлдэгдэл	699,055,330	1,265,945,730	-342,502,464	00	1,622,498,597
D01	2020 оны 12-р сарын 31-нэээрх үлдэгдэл	699,055,330	1,265,945,730	-342,502,464	00	1,622,498,597
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00	00	711,820	00	711,820
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	699,055,330	1,265,945,730	-341,790,644	00	1,623,210,417
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00	-711,820	00	00	-711,820
D08	Тайлант үеийн үр дүн	00	00	1,491,010,852	00	1,491,010,852
D09	2021 оны 12-р сарын 31-нэээрх үлдэгдэл	699,055,330	1,265,233,910	1,149,220,208	00	3,113,509,449

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,742,837,892	1,733,812,200
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,429,000	15,689,430

120	Нийтлэг татварын бус орлого	3,429,000	15,689,430
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,429,000	15,689,430
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	400,000	600,000
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,029,000	15,089,430
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,739,408,892	1,718,122,770
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,628,251,200	1,569,339,100
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,450,000	62,363,353
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00	10,600,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00	49,694,420
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000	2,068,933
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	950,000	00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	85,156,300	86,355,200
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	85,156,300	86,355,200
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	23,551,392	65,117
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	23,551,392	65,117
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,742,837,892	1,733,812,200
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,742,837,892	1,733,812,200
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,582,044,452	1,612,867,931
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,316,939,343	1,271,769,207
210101	Үндсэн цалин	926,323,823	874,319,698
210102	Нэмэгдэл	267,736,287	323,549,856
210104	Урамшуулал	122,879,234	73,899,654
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	159,194,228	166,533,997
210201	Тэтгэврийн даатгал	107,768,558	115,458,097
210202	Тэтгэмжийн даатгал	13,226,370	12,769,000
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,665,300	10,215,100
210204	Ажилгүйдлийн даатгал	2,666,300	2,553,800
210205	Эрүүл мэндийн даатгал	24,867,700	25,538,000
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,772,157	83,103,366
210301	Гэрэл, цахилгаан	13,191,557	9,812,922
210302	Түлш, халаалт	40,057,100	72,398,000
210303	Цэвэр, бохир ус	523,500	892,444
2104	Хангамж, бараа материалын зардал	15,729,014	9,094,033
210401	Бичиг хэрэг	1,185,000	1,524,133
210402	Тээвэр, шатахуун	8,012,260	3,762,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,897,954	937,300
210404	Ном, хэвлэл	860,500	539,300
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	670,100	456,700
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,103,200	1,874,000
2105	Нормативт зардал	29,739,700	41,345,350
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,818,900	2,145,000
210502	Хоол, хүнс	19,863,200	36,662,750
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,057,600	2,537,600
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	650,000	6,964,400
210604	Урсгал засвар	650,000	6,964,400
2107	Томилолт, зочны зардал	540,000	457,100
210702	Дотоод албан томилолт	540,000	457,100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392,000	12,680,578
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00	11,672,578
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000	1,008,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,088,010	20,919,900
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	602,900	13,600,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,485,110	7,319,900

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	160,793,440	120,944,269
2132	Бусад урсгал шилжүүлэг	50,736,792	87,453,637
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	23,551,392	65,117
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	27,185,400	37,694,100
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	00	49,694,420
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00	32,087,698
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00	32,087,698
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00	1,402,934
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00	1,402,934
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	110,056,648	00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	110,056,648	00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,739,463,100	1,604,700,752	1,622,803,768	1,622,803,768
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,739,463,100	1,604,700,752	1,622,803,768	1,622,803,768
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,652,533,500	1,550,928,595	1,539,700,402	1,539,700,402
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,279,163,100	1,316,939,343	1,266,994,282	1,266,994,282
210101	Үндсэн цалин	901,232,100	926,323,823	868,472,194	868,472,194
210102	Нэмэгдэл	283,301,600	267,736,287	323,549,856	323,549,856
210104	Урамшуулал	94,629,400	122,879,234	74,972,232	74,972,232
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	172,687,000	159,194,228	172,381,600	172,381,600
210201	Тэтгэврийн даатгал	121,520,600	107,768,558	121,305,600	121,305,600
210202	Тэтгэмжийн даатгал	12,791,600	13,226,370	12,769,000	12,769,000
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,233,300	10,665,300	10,215,200	10,215,200
210204	Ажилгүйдлийн даатгал	2,558,200	2,666,300	2,553,800	2,553,800
210205	Эрүүл мэндийн даатгал	25,583,300	24,867,700	25,538,000	25,538,000
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	86,929,600	53,772,157	83,103,366	83,103,366
210301	Гэрэл, цахилгаан	10,743,400	13,191,557	9,812,922	9,812,922
210302	Түлш, халаалт	75,386,200	40,057,100	72,398,000	72,398,000
210303	Цэвэр, бохир ус	800,000	523,500	892,444	892,444
2104	Хангамж, бараа материалын зардал	8,005,500	11,200,014	8,349,100	8,349,100
210401	Бичиг хэрэг	834,200	1,185,000	834,200	834,200
210402	Тээвэр, шатахуун	3,206,800	3,483,260	3,762,600	3,762,600
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	947,300	1,897,954	937,300	937,300
210404	Ном, хэвлэл	741,500	860,500	539,300	539,300
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	401,700	670,100	401,700	401,700
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,874,000	3,103,200	1,874,000	1,874,000
2105	Нормативт зардал	101,717,200	29,739,700	40,021,350	40,021,350
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	501,000	6,818,900	821,000	821,000
210502	Хоол, хүнс	98,858,600	19,863,200	36,662,750	36,662,750

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,357,600	3,057,600	2,537,600	2,537,600
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000	650,000	1,848,900	1,848,900
210604	Урсгал засвар	1,000,000	650,000	1,848,900	1,848,900
2107	Томилолт, зочны зардал	540,700	540,000	457,100	457,100
210702	Дотоод албан томилолт	540,700	540,000	457,100	457,100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	392,000	392,000	1,008,000	1,008,000
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	392,000	392,000	1,008,000	1,008,000
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,987,500	5,087,910	20,919,900	20,919,900
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,350,000	1,319,200	13,600,000	13,600,000
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,637,500	3,768,710	7,319,900	7,319,900
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	00		27,720,170	27,720,170
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00		00	00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00		00	00
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	00		00	00
2132	Бусад урсгал шилжүүлэг	81,040,500	27,185,400	27,720,170	27,720,170
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	81,040,500	27,185,400	27,720,170	27,720,170
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,740,312,000	1,604,300,752	1,622,803,768	1,622,803,768
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,650,183,500	1,518,194,452	1,537,251,402	1,537,251,402
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,650,183,500	1,518,194,452	1,537,251,402	1,537,251,402
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	88,778,500	85,156,300	84,952,366	84,952,366
132001	Орон нутгийн төсвөөс	88,778,500	85,156,300	84,952,366	84,952,366
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,350,000	950,000	600,000	600,000
1E+06	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,350,000	950,000	600,000	600,000
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	111	111	111	111
620001	Удирдах ажилтан	01	01	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	67	67	67	67
620003	Үйлчлэх ажилтан	43	43	43	43
620004	Гэрээт ажилтан	00		00	00

2.6. Нэмэлт санхүүжилтийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,579,000	67,543,970
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,579,000	67,543,970
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,579,000	17,784,433
2104	Хангамж, бараа материалын зардал	1,500,000	744,933

210401	Бичиг хэрэг		689,933
210402	Тээвэр, шатахуун	1,500,000	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		55,000
2105	Нормативт зардал		1,324,000
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		1,324,000
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,079,000	5,115,500
210604	Урсгал засвар	2,079,000	5,115,500
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		10,600,000
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		10,600,000
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	49,759,537
2132	Бусад урсгал шилжүүлэг		49,759,537
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		65,117
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг		49,694,420
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3579.000	67,543,970
2260	НД-ЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ		65,117
107	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих		65,117
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС		5,115,500
112	Төсвийн байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		5,115,500
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	3,579,000	62,363,353
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл		10,600,000
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		49,694,420
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000	2,068,933
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	2,079,000	-

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган сумын ерөнхий боловсролын 1 дүгээр дунд сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Шалгагдагч байгууллагад төсвийн зарцуулалттай холбоотой зөвлөмж хүргүүлээ.

Аудитыг Тунгалаг бүртгэл аудит ХХК-ны аудитор Ч. Мөнхцооз 2022 оны 2 дугаар сарын 13-нээс 2021 оны 2 дугаар сарын 16-ны хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 1 дүгээр сарын 23-ний өдрийн 12 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

“Хүүхдийн хөгжлийг дэмжсэн хичээл сургалтыг үр дүнтэй зохион байгуулж, өөрийн удирдлагатай, суралцах арга барил зэмшсэн, өөртөө итгэлтэй, зэрэг хандлагатай хүүхэд төлөвшүүлнэ” гэсэн зорилго дэвшүүлсэн.

Цар тахалтай хүнд цаг үед манай сургууль нь хичээлийн хоцрогдолыг арилгахаар танхимаар болон цахимаар хичээллэж хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх үйл ажиллагаагаа тасралтгүй зохион байгуулан ажилласан.

Тус сургуульд 44 бүлэгт 1178 суралцагч, үүнээс эрэгтэй 591, эмэгтэй 587 сурагчтай. 420 хүүхдийн багтаамжтай хичээлийн 1 дүгээр байранд 641 сурагч, 320 хүүхдийн багтаамж бүхий хичээлийн 2 дугаар байранд 537 хүүхэд, 80 хүүхдийн багтаамж бүхий дотуур байранд 102 хүүхэд, 18 га талбай бүхий хичээл туршлагын талбайтайгаар сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг 1, 2 дугаар ээлжээр явуулдаг.

Нийт багш нараас 23 заах аргач, 28 тэргүүлэх багш мэргэжлийн зэрэгтэй, нийт багш нарын 86,4 хувь нь зэрэгтэй багш нар ажиллаж байна.

2020-2021 оны хичээлийн жилд бага боловсролыг 90 сурагч, суурь боловсролыг 109 сурагч, бүрэн дунд боловсролыг 64 сурагч тус тус амжилттай суралцаж төгсгөсөн.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолоор “төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон бөгөөд 2018 оноос хойш шинэчлэлт хийгдээгүй.

2021 онд аймгийн Засаг даргын тамгын газраас хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн болон Засаг даргын дэргэдэх дотоод аудитын албанаас санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй, төрийн аудитын газраас 2020 оны санхүүгийн тайланд аудит хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган сумын ерөнхий боловсролын 1 дүгээр дунд сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны батлагдсан төсвөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2021 оны батлагдсан төсвийн 1573414,7 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 31468,3 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон, санхүүгийн тайлангийн түвшинд гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 25174,6 мянган төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган сумын ерөнхий боловсролын 1 дүгээр дунд сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1501432,3 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сургуулийн спорт заалны барилгын барилга угсралтын ажлын тендерт Хатан түнгэл ХХК шалгарч 1500,0 сая төгрөгийн үнэтэй спорт заалны барилгыг барьж ашиглалтанд хүлээлгэн өгч данс бүртгэлд тусгаснаар барилга байгууламжийн дүн 1500,0 сая төгрөгөөр өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, үндсэн хөрөнгийн дансдууд байна.

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэлгүй байна.

Тайлант онд авлага өмнөх оноос 13900,0 мянган төгрөгөөр өссөн нь цахим засаглалын хүрээнд Санко маркетинг монголиа ХХК-аас ухаалаг самбар авахаар Аймгийн Засаг даргын А/840 тоот захирамжаар 13,0 сая төгрөг шилжүүлсэн боловч хөрөнгөө он дотроо багтаан нийлүүлээгүйгээс авлага үүссэн байна. Мөн 2 хүнээс суутгаагүй урьдчилгааны үлдэгдэл 900,0 мянган төгрөгийг авлагаар бүртгэн тайлагнасан зэргээр авлага өссөн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 87831,9 мянган төгрөг болж 4088,4 мянган төгрөгөөр буюу 4,8 хувиар өссөн байна. Энэ нь бичиг хэрэг аж материал, 987,5, түлшний үлдэгдэл 16734,8 мянган төгрөгөөр тс тус өсөж хүнсний материал 11421,9 мянган төгрөгөөр буурсан зэрэг хөдлөл өөрчлөлттэй холбоотой байна.

Тайлангийн хугацаанд төсвийн хөрөнгөөр 136755,9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, үнэ төлбөргүйгээр БС-н Газраас 1369,0 мянган төгрөгийн эм, ариутгалын бодис нийлүүлж нийт 140541,0 мянган төгрөгийн орлого бүртгэж, 136452,7 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл цэвэр дүнгээрээ оны эхэнд 1538696,0 мянган төгрөг, оны эцэст 3022199,0 мянган төгрөг болж 1483503,0 мянган төгрөгөөр өссөн нь спорт заалны барилга болон төсвийн хөрөнгөөр худалдан авсан 11115,5 мянган төгрөгийн мотор, цахим самбар, хэвлэгч, Сумын орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлэн 20450,0 мянган төгрөгийн өнгөт принтер, гэрэл зургийн аппарат, notebook, чанга яригч теннисны ширээ, сагсны шийд зэрэг 14 нэрийн тонтог төхөөрөмж, 33753,7 мянган төгрөгийн 36 нэр төрлийн тавилга эд хогшил / Улаанбүрд ХХК, Тома Алтай ХХК, Олимпус спортинг гүүдс ХХК, Хашхан ХХК -ууд нийлүүлсэн/, БС газраас 3 нэрийн сандал тавиур зэрэг 577,9 мянган төгрөгийн хөрөнгө, 3316,9 мянган төгрөгийн ном, Боловсролын чанарын шинэчлэл төслийн хүрээнд “Цахим орчих -хөгжлийн түлхүүр” төслөөр 10,6 сая төгрөг орж ирснээс Тэмүүлэл принт ХХК-наас 9600,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, иргэдээс өгсөн хандиваар 1037,3 мянган төгрөгийн ширээ, сандал хүлээн авсан зэргээр 77301,4 мянган төгрөгөөр товилга эд хогшил, номын үлдэгдэл нэмэгдсэн байна.

Тайлант онд цалин хөлсний программын тооцоолол алдаатай байснаас 6 дугаар сард ажиллагсадад олгох цалингийн дүн илүү тооцогдсоноор хүмүүсээс 10421,5 мянган төгрөгийг гарт олгох дүнгээс суутган тооцсон байна. Энэ алдааг оны сүүлээр дахин хянахад суутган тооцсон нь алдаатай байснаас хамаарч 10421,5 мянган төгрөгийн өглөг үүссэн байна.

Тайлант хугацаанд Сумын ИТХ-н 2021 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 06 тоот тогтоолоор 66 нэр төрлийн 730 ширхэг тавилга эд хогшил, 67 нэрийн 566 ширхэг техник тоног төхөөрөмж нийт 33192,0 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан байна.

Балансын хугацаанд сургуулийн спорт заалны барилга шинээр ашиглалтанд орж үндсэн хөрөнгө өссөн, авлага, өглөг нэмэгдсэн зэрэгтэй холбоотойгоор тайлангийн үеийн үр дүн 1491010,8 мянган төгрөгөөр өсөж хуримтлагдсан үр дүн нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны эхний үлдэгдэл 1622498,6 мянган төгрөг байснаа оны эцэст 3113509,4 мянган төгрөг болж өссөн нь тайлант үеийн үр дүн 1491010,8 мянган төгрөгийн ашигтай гарч, акталсан хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжилтээр 711,8 мянган төгрөгөөр өмнөх үеийн үр дүн өссөн зэрэг ажил гүйлгээг бүртгэн тайлагнасан нь нөлөөлжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Булган сумын ерөнхий боловсролын 1 дүгээр дунд сургуулийн 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1743171,1 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1743171,1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчаас тус байгууллагын төсвийг 1699294,3 мянган төгрөгөөр батлан ирүүлжээ.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд 1699294,3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1612339,1 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 86355,2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс / тогтмол зардлыг санхүүжүүлэх/, 600,0 мянган төгрөгийг төлбөртэй үйлчилгээний орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1569339,1 мянган төгрөгийг улсын төсвөөс төсвөөс, 86355,2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс / тогтмол зардлыг санхүүжүүлэх/, 600,0 мянган төгрөгийг төлбөртэй үйлчилгээний орлого нийт 1656294,3 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс улсын төсвийн санхүүжилтээс 32087,6 мянган төгрөгийг, орон нутгийн төсвийн санхүүжилтээс 1402,9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлж 1622803,8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1622803,8 мянган төгрөг буюу 98,0 хувьтай байгаа нь Цалин хөлс, нэмэгдэл урамшлын зардлыг 8730,1 мянган төгрөгөөр, түлш халаалтын зардлыг 1402,9 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардал 5859,9. Үдийн цайны мөнгө 17497,5 мянган төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант хугацаанд нэмэлт дансаар БСГазраас хөдөө орон нутагт тогтвор сууршилтай ажилласны тэтгэмжинд 49694,4 мянган төгрөг, “Цахим орчих -хөгжлийн түлхүүр” төслөөр 10600,0 мянган төгрөг, НДсангаас олгосон тэтгэмж 65,1 мянган төгрөг, төлбөртэй үйлчилгээний орлогоор 5115,5 мянган төгрөг, БСГ-аас Ковид-19 цар тахалын хүрээнд олгосон ариутгал халдваргүйжүүлэлтийн зардалд 2068,9 мянган төгрөг, нийт 67543,9 мянган төгрөгийн орлого орж тус тусын зориулалтын дагуу зарцуулагджээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого зарлагын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АДБОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АДБОУС 701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх,

нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасны дагуу тус байгууллагын 2021 оны Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хяналаа.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 119 мэдээллээс хугацаандаа 116 мэдээллийг хугацаандаа оруулж, 3 мэдээлэл хугацаа хожимдож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ. Гэвч аудитын явцад бид улирлын тайлан, худалдан авах ажиллагааны мэдээллийг цаг хугацаандаа шилэн дансанд тэдээлсэн эсэхийг хянахад

Бидний хянаснаар цалин шимтгэлийн гүйлгээнээс бусад 219 ажил гүйлгээний 349786,2 мянган төгрөгийн олонлогоос 5,0 сая төгрөгнөөс дээших 23 ажил гүйлгээний 232688,9 мянган төгрөгийн мэдээллийг уг сайтад байршуулахаар байна. Энэ ажил гүйлгээнүүд бүрэн мэдээлэгджээ. Харин авлага өр төлбөр үүссэн тухай мэдээллийг оруулаагүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

1.1. Нүүрсний тооцоо хийж зарцуулалтыг хянаагүй, норм нормативаас хэтрүүлэн зарцуулсан, их хэмжээгээр бэлтгэж нөөцөлсөн, хөрөнгө материалын тооллого хийгээгүй, зарцуулалтад тавих хяналт сул байгаа 3248.0 мянган төгрөгийн зөрчил илэрч. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж е-баримтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг зөвлөжээ.

Уг зөвлөмжийн хэрэгжилтийг хангах 6 төрлийн ажлыг зохион байгуулж үр дүн болон хэрэгжилтийг хангасан тухайгаа 2021 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн 39 тоот албан бичигээр Аудитын газарт хүргүүлжээ. Үүнээс үзэхэд өмнөх аудитаар өгсөн зөвлөмж 80 хувиар хэрэгжсэн гэж үзлээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын зарцуулалтыг авч үзэх нь зүйтэй гэжээ. Аудитын явцад бид бараа материалын зарцуулалтыг анхан шатны баримтын хүрээнд хянаж үзлээ.

2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар цахим засаглалын хүрээнд Санко маркетинг монголиа ХХК-аас ухаалаг самбар авахаар Аймгийн Засаг даргын А/840 тоот захирамжаар 13,0 сая төгрөг шилжүүлсэн боловч хөрөнгөө он дотроо багтаан нийлүүлээгүй асуудлыг дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 22077,9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 22077,9, мянган төгрөгийн алдааг залруулж, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй зөрчлийг арилгах 1 албан шаардлага, түлш, нүүрсний зарцуулалтанд тавих дотоод хяналтыг сайжруулах 1 төрлийн зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санко маркетинг монголиа ХХК-аас ухаалаг самбар авахаар 13,0 сая төгрөг шилжүүлсэн боловч уг самбарыг хүлээн аваагүй байхад үндсэн хөрөнгөнд орлогоор бүртгэн тайлагнасан алдаа илэрсэн
2. Төслийн хүрээнд бэлтгэн нийлүүлсэн 5950,0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг бараа материал дансанд ангилал зөрчиж бүртгэсэн
3. Туслах аж ахуйгаас хураан авч хүүхдийн хоол хүнсэнд 2416,1 мянган төгрөгийн хүнсний ногоог зарцуулсан боловч худалдан авсанаар бүртгэн тайлагнасан алдаа илэрсэн
4. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр акталж данснаас хассан үндсэн хөрөнгийн 711,8 мянган төгрөгийн дахин үнэлгээний хэрэгжилтийг бүртгэж тайлагнаагүй зөрчил илэрсэн

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад дээрхи алдааны 22077,9 мянган төгрөгийн алдааны залруулга хийхийг шалгагдагч байгууллагын удирдлагад асуудлын бүртгэлээр танилцуулж, шалгагдагч байгууллага тухайн бүртгэлийг аудитын явцад залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын дагуу батлагдсан төсвийн 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй зөрчлийн асуудлыг нэгдсэн тайлангийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж гэв.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

4.4.1 Төсвийн зарцуулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт: Түлээ нүүрсний үлдэгдэл 2019 онд 170тн, 2020 онд 126 тн, 2021 онд 218,8 тн болж өмнөх онуудаас 48-92,8 тн-оор илүү нөөцөлсөн зөрчил байна.

Эрсдэл: Төсвийн үрэлгэн зарцуулалт үүсэх, үнэлгээ болон хуваарилалтын батламж мэдэгдэл хэрэгжихгүй байх

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" гэснийг мөрдөн хэрэгцээнээс илүү хэмжээгээр нөөцлөх байж, зарцуулалт, хүлээн авалтанд тавих хяналтыг сайжруулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Булган сумын 1 дүгээр сургууль	5	22077,9	4	22077,9	0	0	0	0	1	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* Х.БОЛДБААТАР

Огноо: 2022. 02.16

АУДИТЫН МЕНЕЖЕР *[Signature]* А.ЦЭЦЭГСҮРЭН

Огноо: 2022. 02.16

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР *[Signature]* Ч.МӨНХЦООЗ

Огноо: 2022. 02.16